



**СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2026 оны 01 сарын 30 өдөр

Дугаар A/24

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай


Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Барилгын тухай хуулийн 37.2 дахь хэсэг, 37.1.6 дахь заалт, "Дүрэм шинэчлэн батлах тухай" Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоол, 2023 оны 278 дугаар тогтоолоор батлагдсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам", "Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай" 2024 оны 02 дугаар тогтоол, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 49 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улс, Нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгө, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө болон хандив, зээл, тусламж, төр ба хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хэрэгжиж буй төсөл арга хэмжээ, хөрөнгө оруулалтын ажлуудыг хүлээн авах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 1 дүгээр, Бараа, тоног төхөөрөмж хүлээн авах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 2 дугаар, Зөвлөх үйлчилгээний ажлыг хүлээн авах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 3 дугаар, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр онц байдал, гамшиг, ослын нөхцөл байдлын улмаас бий болсон хэрэгцээ, шаардлагыг даван туулахтай шууд холбогдох бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 4 дүгээр, Төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр санхүүжүүлэх өөрийн хэрэгцээнд бараа, ажил, үйлчилгээ шууд худалдан авах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 5 дугаар, Зураг төсөв боловсруулах үйлчилгээг шууд худалдан авах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 6 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Холбогдох хууль, дүрэм, журмын хүрээнд тендерийн баримт бичигт өгөгдсөн техникийн тодорхойлолт, батлагдсан ажлын даалгавар, зураг, төсөвт нийцүүлэн хүлээн авах болон худалдан авах ажил зохион байгуулахыг ажлын хэсгийн дарга нарт, бүтээн байгуулалт, худалдан авалтын үр дүнд бий болсон хөрөнгийг данс бүртгэлд тусган, тайлагнаж ажиллахыг байгууллагын дарга нарт үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан дүүргийн Засаг даргын 2025 оны A/56 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.БАТТӨР

E:\2026\Засаг дарга\Захирамж.docx

1826010209

9023100758
9091904 @ СБТ23271

Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын
2026 оны .DI. дугаар сарын 30-ны өдрийн
А.Э. дугаар захирамжийн 1 дүгээр хавсралт



Хөрөнгө оруулалтын ажлыг хүлээн авах
ажлын хэсгийн бүрэлдэхүүн

| | |
|-----------------------|---|
| Ажлын хэсгийн ахлагч: | Дүүргийн менежер |
| Нарийн бичгийн дарга: | Гүйцэтгэгч байгууллагын төлөөлөл |
| Гишүүд: | Төлөвлөлт, гүйцэтгэлийн удирдлагын хэлтсийн инженер |
| | Санхүү, төрийн сангийн хэлтсийн Хөрөнгө оруулалт, орон нутгийн өмч хариуцсан мэргэжилтэн |
| | Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэлд хяналт шинжилгээ үнэлгээ хийх мэргэжилтэн |
| | Хотын стандарт тохижилт нийтийн аж ахуйн хэлтсийн мэргэжилтэн |
| | Архивын хэлтсийн архивч-зааварлагч арга зүйч |
| | Санхүүгийн тасгийн Үндсэн хөрөнгийн нярав |
| | Газар зохион байгуулалтын албаны мэргэжилтэн (зөвшилцсөнөөр) |
| | Захиалагчийн алба ОНӨААТҮГ-ын инженер |
| | Зураг төсөл зохиогч байгууллагын төлөөлөл |
| | Ашиглалт хариуцах байгууллагын төлөөлөл |
| | Хөгжлийн бэрхшээлтэй иргэний төлөөлөл |

Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын
2026 оны 01 дугаар сарын 30 ны өдрийн
А.А. дугаар захирамжийн 2 дугаар хавсралт



Бараа, тоног төхөөрөмж хүлээн авах
ажлын хэсгийн бүрэлдэхүүн

Ажлын хэсгийн ахлагч:

Санхүүгийн тасгийн дарга

Нарийн бичгийн дарга:

Гүйцэтгэгч байгууллагын төлөөлөл

Гишүүд:

Төлөвлөлт, гүйцэтгэлийн удирдлагын
хэлтсийн орон нутгийн хөгжил, хөрөнгө
оруулалтын бодлого, төлөвлөлт хариуцсан
мэргэжилтэн

Санхүү, төрийн сангийн хэлтсийн Хөрөнгө
оруулалт, орон нутгийн өмч хариуцсан
мэргэжилтэн

Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн
хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэлд
хяналт шинжилгээ үнэлгээ хийх
мэргэжилтэн

Архивын хэлтсийн архивч-зааварлагч
арга зүйч

Санхүүгийн тасгийн Үндсэн хөрөнгийн
нярав

Захиалагчийн алба ОНӨААТҮГ-ын инженер

Ашиглалт хариуцах байгууллагын төлөөлөл

Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын
2026 оны 01 дугаар сарын 30 ны өдрийн
А/Н дугаар захирамжийн 3 дугаар хавсралт



Зураг төсвийн, ажлыг хүлээн авах
ажлын хэсгийн бүрэлдэхүүн

Ажлын хэсгийн ахлагч:

Төлөвлөлт, гүйцэтгэлийн удирдлагын
хэлтсийн дарга

Нарийн бичгийн дарга:

Төлөвлөлт, гүйцэтгэлийн удирдлагын
хэлтсийн инженер

Гишүүд:

Санхүү, төрийн сангийн хэлтсийн Хөрөнгө
оруулалт, орон нутгийн өмч хариуцсан
мэргэжилтэн


Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн

Хотын стандарт тохижилт нийтийн аж
ахуйн хэлтсийн мэргэжилтэн

Захиалагчийн алба ОНӨААТҮГ-ын инженер

Дэд бүтцийн хөгжлийн алба ОНӨААТҮГ-ын
инженер

Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын
2026 оны ᠒.᠕. дугаар сарын 30-ны өдрийн
А/АЧ. дугаар захирамжийн 4 дүгээр хавсралт



Онц байдал, гамшиг, ослын нөхцөл байдлын үед бараа, ажил
үйлчилгээг худалдан авах ажлын хэсгийн бүрэлдэхүүн

Ажлын хэсгийн ахлагч:

Дүүргийн менежер

Нарийн бичгийн дарга:

Санхүү, төрийн сангийн хэлтсийн Хөрөнгө
оруулалт, орон нутгийн өмч хариуцсан
мэргэжилтэн

Гишүүд:

Төлөвлөлт, гүйцэтгэлийн удирдлагын
хэлтсийн дарга

Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга

Хотын стандарт тохижилт нийтийн аж
ахуйн хэлтсийн дарга

Онцгой байдлын хэлтсийн дарга

Цагдаагийн газрын дарга

Эрүүл мэндийн төвийн дарга

Газар зохион байгуулалтын албаны дарга

Санхүүгийн тасгийн дарга

Архивын хэлтсийн архивч-зааварлагч
арга зүйч

Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын
2026 оны 01 дугаар сарын 30-ны өдрийн
А/Н дугаар захирамжийн 5 дугаар хавсралт



Бараа, ажил, үйлчилгээ шууд худалдан авах
ажлын хэсгийн бүрэлдэхүүн

Ажлын хэсгийн ахлагч:

Аж ахуйн тасгийн дарга

Нарийн бичгийн дарга:

Хариуцагчийн гэрээ, түүний хэрэгжилт
хариуцсан ажилтан

Гишүүд:

Санхүүгийн тасгийн дарга

Төрийн захиргааны удирдлагын
хэлтсийн ахлах мэргэжилтэн

Санхүү, төрийн сангийн хэлтсийн ахлах
мэргэжилтэн


Төлөвлөлт, гүйцэтгэлийн удирдлагын
хэлтсийн инженер

Хотын стандарт тохижилт нийтийн аж
ахуйн хэлтсийн мэргэжилтэн

Санхүүгийн тасгийн Үндсэн хөрөнгийн
нярав

Ашиглалт хариуцах байгууллагын төлөөлөл

Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын
2026 оны 01 дугаар сарын 30 ны өдрийн
А/А дугаар захирамжийн 6 дугаар хавсралт



Зураг төсөв боловсруулах үйлчилгээг шууд худалдаа авах
ажлын хэсгийн бүрэлдэхүүн

Ажлын хэсгийн ахлагч:

Төлөвлөлт, гүйцэтгэлийн удирдлагын
хэлтсийн дарга

Нарийн бичгийн дарга:

Төлөвлөлт, гүйцэтгэлийн удирдлагын
хэлтсийн инженер

Гишүүд:

Санхүү, төрийн сангийн хэлтсийн Хөрөнгө
оруулалт, орон нутгийн өмч хариуцсан
мэргэжилтэн

Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн

Хотын стандарт тохижилт нийтийн аж
ахуйн хэлтсийн мэргэжилтэн